

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ЯАМНААС 2009 ОНЫ 04 ДҮГЭЭР САРД  
ХИЙСЭН ГОЛ АЖИЛ**

**Нэг. Бодлого төлөвлөлтийн асуудлаар:**

1. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудал:

- “Малчдын талаар төрөөс баримтлах бодлого”-ын төслийг хэлэлцүүлж, УИХ дахь намын бүлгүүд болон байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж эхлэв.
- “Засгийн газарт эрх олгох” тухай хуулийн төслийг хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэв.
- “Тариалангийн тухай” хуулийн төслийг хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэв.
- “Хаврын тариалалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцүүлж, шийдвэр гаргуулав.

2. Судалж, боловсруулсан асуудлын талаар:

- ХХААХҮ-н салбарын бодлогын зорилтыг хэрэгжүүлэх 2010-2012 оны дунд хугацааны төсвийн төлөвлөгөөг Үндэсний хөгжил шимэтгэлийн хороонд хүргүүлэв.
- Согтууруулах ундааны стандартын төслийг боловсруулж СТХҮТ-д хүргүүлэв
- Хүнсний хууль эрх зүйн хорооны 1993 оны 20 дугаар хуралдаанаар баталсан “Нийтийн хоолны үйлдвэрлэлд мөрдөх эрүүл ахуйн дадал” САС/РСР-39-19931 стандартын төсөлд холбогдох байгууллагуудын саналыг авч тусган, Хүнсний стандартчилалын техникийн хороонд хүргүүлэв.
- “Технологи дамжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн үзэл баримтлалыг БСШУЯ-тай хамтран боловсруулж, ХЗДХЯ-д хүргүүлэв.
- Тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжид техникийн лизингийн үйлчилгээ үзүүлэх үед баримтлах “Техникийн лизинг үзүүлэх журам”, “Техникийн лизингийн гэрээ”, “Техникийн лизингийн барьцааны гэрээ” зэрэг бичиг баримтыг боловсруулав.

**Хоёр. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудлаар:**

- Мал хаваржилт хүндрэлтэй байгаа Увс, Ховд, Баян-Өлгий, Завхан, Хөвсгөл аймгуудад ХХААХҮ-ийн дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг, цаг агаарын гамшигт үзэгдэл болох магадлал өндөртэй 15 аймагт ХХААХҮЯ, ОБЕГ, УЦУОШГ-тай хамтарсан ажлын хэсэг тус тус томилон ажиллуулж, Засгийн газрын “Улсын нөөцөөс бараа материал гаргах, нөхөн бүрдүүлэх, тээвэрлэн байршуулах тухай” 127 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, Увс, Баян-Өлгий, Завхан, Хөвсгөл аймагт нийт 253.6 сая төгрөгийн үнэ бүхий өвс тэжээлийг үнэгүй, Төв, Баянхонгор, Дундговь, Сүхбаатар аймагт нийт 1333,6 сая төгрөгийн үнэ бүхий өвс, тэжээлийн үнийг 50 хувиар хөнгөлж олгох, тухайн тэжээлийн холбогдох цэг, салбаруудад байршуулахад шаардагдах тээврийн зардалд 275,0 сая төгрөг, нийт 822,5 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлүүлэв.
- Говь-Алтай, Архангай, Ховд, Завхан, Сэлэнгэ, Төв, Булган, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул аймагт тэжээлийн нэг ба олон наст ургамлын /хошуу будаа 80 тн, хөх тариа 60 тн, царгас 2 тн/ үрийг олгох ажлыг зохион байгуулав.
- Үр, бордоо, үр ариутгалын бодис, алмазис гербицид хүссэн иргэд, аж ахуйн нэгжийн захиалгыг нэгтгэн шийдвэр гаргуулж, олгож эхлээд байна.
- “Царцаатай тэмцэх ажилд шаардагдах ургамал хамгаалах бодис худалдан авах”, “Микробиологийн аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох”, “Тэжээлийн нэг ба олон наст ургамлын үр худалдан авах” тендерүүдийг дүгнэж, шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.
- Химийн уринш бэлтгэх раундап гербицид нийлүүлэгчийг сонгох, 155-180 морины хүчтэй трактор худалдан авах, Сүү, махны чиглэлийн үхэр худалдан авах тендерүүдийн баримт

бичиг болон Бэлчээр, хадлангийн талбай хашаалах төсөл сонгон шалгаруулах баримт бичгийг тус тус боловсруулав.

- ХХААХҮ-ийн салбарт 2008 онд хэрэгжиж дууссан шинжлэх ухааны “Мал, амьтны вируст өвчнийг оношлох, сэргийлэх арга”, “Гадна шимэгч, эгэл биетнээр үүсдэг өвчнүүдтэй тэмцэх арга”, “Төл, өсвөр малын ходоод гэдэсний эмгэгийг анагаах, сэргийлэх зориулалттай биозохицуулагч бэлдмэл” зэрэг төслүүдийг хүлээн авч, үнэлгээ хийв.
- “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих дотоодын хяналт” сэдэвт сургалт семинар зохион байгуулан, “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих дотоодын хяналт” эмхэтгэл гарган хэрэглэгчдэд хүргүүлэв. Сургалтанд НМХГ-ын улсын байцаагч нар, нийтийн хоол үйлдвэрлэгч 50 гаруй аж ахуйн нэгжийн төлөөлөл хамрагдлаа.
- 2009 оны тариалалтанд шаардагдах 17.0 мянган тонн улаанбуудайн үр гаргахтай холбогдуулан улаанбуудайн үрийг цэвэрлэж, МХЕГ-аар дүгнэлт гаргуулах тухай албан даалгаврыг салбаруудад хүргүүлээд байна.  
2009 оны тариалалтад дутагдаж буй 10.0 мянган тонн үрийг аж ахуйн нэгжүүдийн хадгалсан үрнээс авахаар МХЕГ, ТЭДС-ийн хамтарсан ажлын хэсэг Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудад томилолтоор ажиллав.

### **Гурав. Гадаад хамтын ажиллагаа болон дотоод ажлын талаар**

- Дэлхийн банктай хамтран 05 дугаар сарын 19–нд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар уулзалт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.
- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас Засгийн газраар батлуулсан “Хүнсний аюулгүй байдлын хөтөлбөр”-ийг хандивлагчдад танилцуулах Олон улсын хурлын бэлтгэл ажлыг хангах чиглэлээр НҮБ-ын ХХААБ-ын зөвлөхтэй хамтран ажиллаж байна.
- НҮБ-ын ХХААБ-аас санхүүжүүлж, хэрэгжүүлж буй “Монгол Улсад Хүнсний үнийн хөөрөгдөлд өртөгдсөн өрхийн аж ахуйг дэмжих төсөл”-ийн хэрэгжилтийн хүрээнд НҮБ-ын Бээжин дэхь суурин төлөөлөгчийг Монголд ажиллах үеэр төмс, хүнсний ногооны үр тараах ажиллагааг 04 дүгээр сарын 24-ны өдөр зохион байгуулав.
- 04 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд Өмнөд, Өмнөдийн хамтын ажиллагааны хүрээг тодорхойлох, гурван талын хэлэлцээрийн төслийг боловсруулж, ХХААХҮ-ийн сайд Т.Бадамжунай, НҮБ-ын ХХААБ-ын Монголыг хариуцсан суурин төлөөлөгч хатагтай Виктория Секитолело, БНХАУ-ын Засгийн газрыг төлөөлж БНХАУ-ын ХААЯ-ны Гадаад хамтын ажиллагааны төвийн дэд дарга нар Өмнөд Өмнөдийн хамтын ажиллагааны хүрээг тодорхойлсон Санамж бичигт гарын үсэг зурав.
- “Монгол орны төвийн бүсэд мах сүүний эрчимжсэн аж ахуйн малын тэжээлийн үйлдвэрлэл, ашиглалтыг сайжруулах” төслийн хүрээнд Төв, Дархан, Сэлэнгэ аймгуудад газар тариалан эрхлэгчдэд НҮБ-ын ХХААБ-ын Суурин төлөөлөгч тоног төхөөрөмж гардуулах ажиллагааг зохион байгуулав.
- Канад Улсын Гадаад харилцаа, олон улсын худалдааны яамны дэд сайд Леонард Эдвардсын ХХААХҮ-ийн дэд сайд Х.Золжаргалтай хийсэн уулзалтыг зохион байгуулав.
- АНУ-ын Худалдаа хөгжлийн агентлагийн Зүүн хойд Азийн газрын дарга, мэргэжилтэн болон Израил Улсын ГХЯ-ны дэргэдэх Олон улсын хамтын ажиллагааны байгууллага МАШАВ-ын Бээжин дэх төлөөлөгч нарын ХХААХҮЯ-ны ТНБД-тай хийсэн уулзалтыг тус тус зохион байгуулж, АНУ-д биотехнологийн чиглэлээр танилцах аялал хийх болон хүнсний бөөний худалдааны сүлжээ байгуулах талаар техник, эдийн засгийн судалгаа хийхэд туслалцаа, санхүүжилт олгох талаар хүсэлт тавьж, харилцан санал солилцож, Бээжин хотын орчимын Хятад-Израилын хамтарсан Сүүний загвар аж ахуйн үйл ажиллагаатай очиж танилцахаар болов.
- Израил Улсын ГХЯ-ны дэргэдэх Олон улсын хамтын ажиллагааны байгууллага МАШАВ-ын “Сүүний аж ахуйн орчин үеийн менежмент” сургалтыг Улаанбаатар хотноо 04 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд “Сүү” төсөлтэй хамтран Хүнсний технологийн коллежийн Сүүний сургалтын төвийн байранд амжилттай зохион байгууллаа.
- Монгол Улсын ХХААХҮЯ болон ОХУ-ын ХААЯ хоорондын Харилцан ойлголцлолын санамж бичигт гарын үсэг зурсны дагуу ОХУ-аас Хөдөө аж ахуйн салбарт 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн асуудлын хүрээнд хэрэгжих төсөл болон хаврын тариалалтанд шаардлагатай ОХУ-ын хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж, үр тариа,

эрдэс бордоо болон бусад бүтээгдэхүүний нийлүүлэлт, төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

- Дор дурдсан хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийв. Үүнд:
  - “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр,
  - “Хөдөөгийн ядуурлыг бууруулах” хөтөлбөр,
  - “Үхэр, хонь, ямаан сүргийн бруцеллёзтой тэмцэх” төсөл,
  - “Махны экспорт” төсөл,
  - “Агропарк” төсөл,
  - Ноолуурын салбарт 2012 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт,
  - Улсын төсвийн дэмжлэгээр 2008 онд сэргээн засварласан болон шинээр барьсан усалтын системийн барилгын ажлын гүйцэтгэл.

## **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**